АРХАНГАЙ АЙМАГ, ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ ӨЛЗИЙТ ТЭЭЛИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР MV-001410/
/АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТЕРИЙН ДУГААР 2801299/

Улаанбаатар хот. 2025 он

ГАРЧИГ

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА **1**

НЭГ. 2025 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА **1**

ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ **2**

ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ **3**

2.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ **3**

2.2 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ **6**

2.3 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ **9**

2.4 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ **10**

ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТ **11**

3.1 Нөхөн сэргээлтийн ажилд ашигласан тоног төхөөрөмж **11**

3.2 2025 оны нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө гүйцэтгэл **12**

3.3 Техникийн нөхөн сэргээлт **12**

3.3.1 Олборлосон орон зайг нөхөн дүүргэх **12**

3.3.2 Хэлбэржүүлэлтийн ажил **14**

3.3.3 Шимт хөрсөөр хучих **18**

3.4. Биологийн нөхөн сэргээлт **22**

3.4.1 Ойжуулалт **22**

3.4.2 Бэлчээрийн олон наст ургамал тариалсан талбай **27**

3.5. Нөхөн сэргээлтийн ажлын зардал. **30**

ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 31

4.1. Ойн төгөл байгуулах. 31

4.2. Зэрлэг гахай нутагшуулах төслийн хүрээнд хийгдсэн ажлууд 32

4.3. Био техникийн арга хэмжээ. 33

ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН 33

ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН 34

ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТАЙЛАН 34

НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨИЙ БИЕЛЭЛТ 36

ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР 37

АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 39

АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ 40

АРВАН ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АЖЛЫН НИЙТ ЗАРДАЛ 41

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр: Өлзийт тээлийн алтны шороон орд

Байршил: Архангай аймгийн Цэнхэр сум

Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 27 – р хороо, 21-р хороолол, Толгойт гудамж 16 тоот

Утас: 976 – 99993972

E-mail: uurkhai@gmail.mn

Хариуцах хүн: Байгаль орчны мэргэжилтэн С.Мөнхбат **Утас:** 94444610

ААН-ийн нэр: “БМНС” ХХК

НЭГ. 2025 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Олборлолт ❖ Талбай /га/ ❖ Эзэлхүүн /мян.м^3/	 ❖ 6.9 ❖ 1232.0
Техник ❖ Талбай /га/ ❖ Эзэлхүүн /мян.м^3/	 ❖ 15 ❖ 1418.7
Биологи ❖ Талбай /га/ ➢ Бэлчээрийн чиглэлээр нөхөн сэргээсэн талбай /га/ ❖ Олон наст ургамалын үр /кг/ ➢ Ойжуулалтын чиглэлээр нөхөн сэргээсэн талбай /га/ ❖ Үхрийн нүдний бут /ширхэг/ ❖ Хайлаас мод /ширхэг/ ❖ Улиас /ширхэг/ ❖ Чацаргана /ширхэг/	 ❖ 10.0 ➢ 9.0 ❖ 1500.0 ➢ 1.0 ❖ 150.0. ❖ 100.0 ❖ 200.0 ❖ 100.0

Төслийн талбайн байршил

MV-001410 тоот тусгай зөвшөөрлийн талбай нь засаг захиргааны хувьд Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт байрлана. Улаанбаатар хотоос баруун урагш 500 км, Архангай аймгийн Цэнхэр сумаас урагш 70 км тус тус зайтай оршино. Цэнхэр сумаар Монгол улсын хэвтээ тэнхлэгийн Улаанбаатар-Архангай чиглэлийн хатуу хучилттай авто зам дайран өнгөрдөг. Талбайн номенклатур М-47-48, ордын байрлалыг дараах зурагт үзүүлэв.

Ордын байршил

Зураг. 1



Ордын байршилийн сансрын зураг

Зураг. 2



2. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Уул уурхайн үйл ажиллагааны явцад газрын доорх усны нөөцийн бохирдол, хомсдол, ургамлан нөмрөгийн өөрчлөлт, хөрсний элэгдэл, эвдрэл, геологийн тогтцын өөрчлөлт, байгалийн нөөцийн хомсдол, бэлчээрийн талбай багасах, эрчим хүчний хэрэглээ нэмэгдэх, тэрчлэн агаар ус, хөрсний бохирдол үүсэх, химийн бодисоос үүдэн гарах нөлөөлөл зэрэг сөрөг нөлөөллүүд хамаарна.

2.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Хүрээлэн буй орчны агаарын чанарын нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлээд байна.

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

Хүснэгт. 1

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
1	Хөрс хуулалт, элс олборлолт, элс тээвэрлэлт, овоолго үүсгэх зэргээр тоосжилт үүсч агаарын чанарт сөргөөр нөлөөлж, улмаар хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлнэ	Уурхайн технологийн замуудыг хуурайшилттай үеүүдэд 25 тн багтаамж бүхий зам усалгааны машинаар услаж тоосжилтыг дарж байсан. Мөн 10 м/с дээш салхитай үед технологийн ажлуудыг түр зогсоож байв.
2	Тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх	Төслийн талбай орчмын авто машины хөдөлгөөнд хяналт тавьж, хурдын хязгаар тогтоож тэмдэг тэмдэглэгээ байршуулсан, олон салаа зам гаргахгүйн тулд замын маршрут гаргаж, тэмдэгжүүлэн ажилчидад мэдээллэн таниулсан
3	Ахуйн гаралтай хог хаягдал нь ялзарч муудан агаарт эвгүй үнэр гарган агаар орчинг бохирдуулна	Ахуйн хатуу шингэн хаягдлыг битүүмжилж, ялган ангилж хаях, Цэнхэр сумын ЗДТГ-тай гэрээ байгуулан зөвшөөрөгдсөн цэгт тээвэрлэн зайлуулсан /Хог хаягдлын гэрээг хавсаргав/

Технологийн замын усалгаа

Зураг. 3



Технологийн замын усалгаа

Зураг.4



Замын тэмдэг тэмдэглэгээ

Зураг. 5



Замын тэмдэг тэмдэглэгээ

Зураг. 6



2.2 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ

Төслийн талбайд үйл ажиллагааны явцад газрын хэвлий, хөрсөн бүрхэвчинд учруулж болзошгүй сөрөг нөллөөлийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч ажиллаад байна.

Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

Хүснэгт. 3

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
1	Засварын газар болон шатахуун түгээх газарт шатах тослох материал асгарах	Хаягдал тос маслыг битүүмжлэл сайтай саванд хадгалан тусгай зөвшөөрөл бүхий “Монпити-Ойл” ХХК-тай хаягдал тос нийлүүлэх гэрээ байгуулан Улаанбаатар хот руу тээвэрлэсэн.
2	Газар хөндөх, Хөрсөн бүрхэвч хуулах	Шимт хөрсийг 30 см зузаантай хуулан стандартын дагуу хадгалсан.
3	Хуулсан шимт хөрс салхи, усаар зөөгдөж механик бүрэлдэхүүн өөрчлөгдөх, чийгээ алдах	Шимт хөрсийг ус, салхинаас хамгаалж тусгай хэсэгт шимт хөрсний склад байгуулан хаягжуулсан.

Хаягдал тос масло хадгалах сав

Зураг. 7





Шимт хөрс хуулж буй үеийн зураг

Зураг. 8



Шимт хөрс хуулж буй үеийн зураг

Зураг. 9



Шимт хөрсний овоолго байгуулж, хаягжуулав

Зураг.10



2.3 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ

Уурхайн үйл ажиллагааны явцад гадаргын болон гүний усанд бохирдол үүсэхээс сэргийлж дараах арга хэмжээнүүдийг аван ажилласан.

Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

Хүснэгт. 4

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
1	Усны зүй зохисгүй хэрэглээг арилгах	Усыг ариг гамтай хэрэглэх, усан орчныг хэрхэн хайрлан хамгаалах талаар нийт ажилчдад тодорхой давтамжтай сургалт зохион байгуулсан
2	Гүний усны нөөц хомсдох	Гүний усны нөөц хомсдохоос сэргийлж ил уурхайн зам талбайн усалгааг хийхдээ үүсмэл нуураас авч ашигласан

Гадрагын усыг үер болон механик бохирдлоос цэвэршүүлэх зорилгоор байгуулсан шүүн тунгаах далангуудыг засаж сайжруулав. Мөн байгалд нийлүүлж буй уснаас тогтмол дээж авч мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэсэн.

Шүүн тунгаах далан

Зураг. 11



Цэвэршүүлсэн усыг байгальд нийлүүлж байгаа нь

Зураг. 12



2.4 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад авсан арга хэмжээ

Ан амьтан, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалахад чиглэсэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэв.

Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

Хүснэгт. 5

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
1	Төслийн үйл ажиллагаанаас ойролцоох уст цэг бохирдох, усны нөөц хомсдох, ан амьтан усаар гачигдах	Төслийн талбайн усыг цэвэршүүлж ан амьтад ус уух таатай орчинг бүрдүүлсэн
2	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс зэрлэг мал амьтан үргэж дайжих	Тээврийн хэрэгслийг тодорхой маршрутын дагуу явуулж, ан амьтан үргэж, дайжихаас сэргийлсэн

3. НӨХӨН СЭРГЭЭЛТ

“БМНС” ХХК нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэхдээ зохих стандарт, нормыг баримтлан эвдэрсэн газрыг байгалийн унаган төрхөнд ойртуулан хадлан бэлчээр болон ойжуулалтын зориулалтаар нөхөн сэргээж байна.

Нөхөн сэргээлтийн ажлыг техник болон биологийн нөхөн сэргээлт гэсэн үндсэн 2 үе шаттай гүйцэтгэж байна.

Нөхөн сэргээлтийн ажлыг дараах технологи процессын дагуу гүйцэтгэнэ.

- Техникийн нөхөн сэргээлт:
  - Ил уурхайн ухашыг нөхөн дүүргэх
  - Хэлбэржүүлэх, тэгшлэх
  - Шимт хөрсөөр хучих
  - Модны тогоо ухах
- Биологийн нөхөн сэргээлт:
  - Мод тарих
  - Ургамалжуулах
  - Хашаажуулах

3.1 Нөхөн сэргээлтийн ажилд ашигласан тоног төхөөрөмж

2025 оны нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд ашиглагдсан орон зайг нөхөн дүүргэх, хэлбэржүүлэх, шимт хөрсөөр хучих, ургамалжуулах, хашаажуулах зэрэг ажлууд хийгдсэн. Дээрх ажлуудыг гүйцэтгэхдээ дараах тоног төхөөрөмжүүдийг ашигласан.

Нөхөн сэргээлтийн ажилд ашигласан
тоног төхөөрөмжийн жагсаалт

Хүснэгт. 1

№	Тоног төхөөрөмжийн төрөл	Тоног төхөөрөмжийн марк	Хүчин чадал	Тоо ширхэг
1	Экскаватор	Doosan DX800LC	5.6 $м^3$	1
2		Hyundai 520LC	3.2 $м^3$	2
3		Hyundai 290	2.4 $м^3$	1
4	Бульдозер	CAT D8R	8.7 $м^3$	1
5		CAT D6R	4.3 $м^3$	1
6	Утгуурт ачигч	LG953	3.0 $м^3$	2
7	Автосамосвал	Howo	17 $м^3$	11
8	**Нийт**	-	-	**19**

3.2 2025 оны нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл

2025 онд MV-001410 тоот тусгай зөвшөөрлийн талбайн Өлзийт тээл болон Өлийн голын хэсэгт техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэсэн.

Өлзийт тээлийн хэсэгт өмнөх онуудад эвдрэлд өртсөн талбайнуудад нөхөн дүүргэлт, хэлбэржүүлэлт, шимт хөрсөөр хучих, мод тарих, ургамалжуулах зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн болно.

2025 оны нөхөн сэргээх ажлын төлөвлөгөөнд 15.0 га талбайд техник, 10.0 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийгдэхээр тусгагдсан . Доорх хүснэгтэд 2025 оны нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө гүйцэтгэлийг харуулав.

Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт. 2

Нөхөн сэргээх арга хэмжээ	Нэгж	Төлөвлөлтийн хэмжээ	Гүйцэтгэлийн хэмжээ	Гүйцэтгэлийн хувь, %
Нөхөн дүүргэлт	мян.м^3	945.2	1418.7	150
Хэлбэржүүлэх, хажууг налуулах	га	10.0	12.0	120
Шимт хөрсөөр хучих	га	15.0	15.0	100
Ургамалжуулах, мод тарих	га	10.0	10.0	100
Хашаажуулах	м	1825.0	2300.0	126

3.3 Техникийн нөхөн сэргээлт

3.3.1 Олборлосон орон зайг нөхөн дүүргэх

2025 онд MV-001410 тоот тусгай зөвшөөрлийн талбайн Өлийн голын хэсэгт тус онд болон өмнөх жилүүдэд ашиглалт явуулж байсан талбайнуудад нөхөн дүүргэлтийн ажил гүйцэтгэсэн. Доорх хүснэгтэд нөхөн дүүргэлтийн ажлын хэмжээг үзүүлэв.

Нөхөн дүүргэлтийн ажлын хэмжээ

Хүснэгт. 3

№	Үзүүлэлт	Нэгж	Утга
Өлийн гол			
1	Нөхөн дүүргэлт хийгдсэн талбай	га	7.0
2	Нөхөн дүүргэлтийн ажлын хэмжээ	мян.м^3	1418.7

Ашиглагдсан хоосон орон зайг нөхөн дүүргэх үеийн зураг

Зураг. 13



Ашиглагдсан хоосон орон зайг нөхөн дүүргэх үеийн зураг

Зураг. 14



3.3.2 Хэлбэржүүлэлтийн ажил

Өлзийт тээл болон Өлийн голын хэсэгт хэлбэржүүлэлт, налуулалтын ажил гүйцэтгэсэн. Хэлбэржүүлэлтийн ажлыг гүйцэтгэхдээ тухайн хэсгийн байгалын налууд ойртуулж хөдөө аж ахуйн хадлан бэлчээрийн зориулалтаар 15-20 градусын налуутай налуулсан. Нөхөн дүүргэлт болон хэлбэржүүлэлтийн ажилд CAT-D8R, CAT-D6 зэрэг бульдозерууд болон автогрейдер ажилласан. 2025 онд нийт 12.0 га талбайд хэлбэржүүлэлтийн ажил хийгдээд байна. Доорх хүснэгтэд хэлбэржүүлэлтийн ажлын хэмжээг үзүүлэв.

Хэлбэржүүлэлтийн ажлын хэмжээ

Хүснэгт. 4

№	Үзүүлэлт	Нэгж	Утга
Өлзийт тээл			
1	Хэлбэржүүлэлт хийгдсэн талбай	га	7
2	Хэлбэржүүлэлтийн ажлын хэмжээ	мян.м^3	26.4
Өлийн голын			
1	Хэлбэржүүлэлт хийгдсэн талбай	га	8
2	Хэлбэржүүлэлтийн ажлын хэмжээ	мян.м^3	30.6

Өлийн голын хэсгийн хэлбэржүүлэлт хийгдэхээс өмнөх үеийн зураг

Зураг. 15



Өлийн голын хэсгийн хэлбэржүүлэлт хийгдсэний дараах үеийн зураг

Зураг. 16



Өлзийт тээлийн хэсгийн хэлбэржүүлэлт хийгдэх үеийн зураг

Зураг. 17



Хэлбэржүүлэлт хийгдсэн талбайн солбицол

Хүснэгт. 5

№	Солбицол	
	East	North
	Өлийн голын хэсэг	
1	705910.86	5199982.40
2	705913.16	5199964.38
3	705913.33	5199960.40
4	705921.13	5199954.85
5	705930.23	5199946.03
6	705934.99	5199939.82
7	705935.86	5199937.45
8	705936.29	5199932.95
9	705925.44	5199899.22
10	705919.09	5199890.35
11	705898.59	5199862.53
12	705896.22	5199853.99
13	705893.17	5199843.04
14	705891.59	5199833.83
15	705892.00	5199821.96
16	705893.78	5199812.89
17	705897.64	5199796.84
18	705899.40	5199782.51
19	705899.40	5199782.51
20	705899.40	5199782.51
21	706149.52	5199782.51
22	706149.52	5199782.51
23	706149.52	5199782.51
24	706149.32	5199800.00
25	706147.13	5199860.43
26	706145.93	5199881.37
27	706143.60	5199922.24
28	706141.72	5199960.40
29	706140.96	5199989.43
30	706139.68	5200034.65
31	706137.44	5200114.22
32	706137.91	5200118.41
33	706018.82	5200118.51
34	705884.58	5200117.83
35	705883.90	5200092.71
36	705884.81	5200071.25
37	705898.00	5200024.46
38	705910.86	5199982.40
Өлзийт тээл-1		
1	704536.41	5200334.93

2	704528.00	5200313.43
3	704512.85	5200284.98
4	704512.85	5200284.98
5	704506.02	5200288.61
6	704476.99	5200307.52
7	704453.15	5200321.72
8	704438.58	5200329.67
9	704393.23	5200349.07
10	704383.98	5200353.48
11	704352.09	5200369.41
12	704324.69	5200381.15
13	704310.57	5200388.27
14	704278.69	5200409.07
15	704224.77	5200450.19
16	704196.41	5200462.23
17	704165.45	5200476.83
18	704147.37	5200489.26
19	704127.25	5200512.60
20	704113.96	5200531.48
21	704105.75	5200556.82
22	704106.85	5200571.54
23	704118.25	5200597.09
24	704123.37	5200608.55
25	704156.97	5200586.58
26	704196.93	5200562.69
27	704207.22	5200556.82
28	704246.39	5200530.03
29	704265.37	5200519.83
30	704306.37	5200496.23
31	704393.17	5200442.79
32	704427.45	5200423.27
33	704448.22	5200413.35
34	704455.79	5200406.94
35	704472.35	5200389.56
36	704499.11	5200361.48
37	704507.82	5200355.48
38	704517.28	5200348.96
39	704536.41	5200334.93
40	704536.41	5200334.93
41	704536.41	5200334.93
42	704536.41	5200334.93
43	704536.41	5200334.93
44	704536.41	5200334.93
45	704536.41	5200334.93
Өлзийт тээл-2		
1	702664.53	5201945.61

2	702650.80	5201974.61
3	702635.74	5202002.74
4	702634.29	5202004.69
5	702653.89	5202031.86
6	702723.42	5202128.23
7	702723.42	5202128.23
8	702859.33	5201999.28
9	702859.33	5201999.28
10	702842.97	5201969.50
11	702783.79	5201929.70
12	702771.15	5201921.52
13	702738.68	5201913.10
14	702684.72	5201861.19
15	702640.93	5201919.29
16	702664.53	5201945.61

3.3.3 Шимт хөрсөөр хучих

Тус онд Өлзийт тээл болон Өлийн гол хэсэгт тус онд хэлбэржүүлэлт хийгдсэн 15 га талбайг шимт хөрсөөр хучсан. Шимт хөрсөөр хучих ажилд 10 ш автосамосвал, 2 ш утгуурт ачигч, CAT D6 бульдозер, автогрейдер зэрэг тоног төхөөрөмжүүд ажилласан. Доорх хүснэгтэд шимт хөрс хучилтын ажлын хэмжээг харуулав.

Шимт хөрсөөр хучилтын ажлын хэмжээ

Хүснэгт. 6

№	Үзүүлэлт	Нэгж	Утга
Өлийн гол			
1	Шимт хөрсөөр хучсан талбай	га	8.0
2	Ажлын хэмжээ	мян.м^3	16.0
Өлзийт тээл			
1	Шимт хөрсөөр хучсан талбай	га	7.0
2	Ажлын хэмжээ	мян.м^3	14.0

Өлийн голын хэсгийн шимт хөрс буулгах үеийн зураг

Зураг.18



Өлийн голын хэсгийн шимт хөрс тараах үеийн зураг

Зураг.19



Өлийн голын хэсгийн шимт хөрс тараах үеийн зураг

Зураг. 20



Өлийн голын хэсгийн шимт хөрс тараах үеийн зураг

Зураг. 21



Өлзийт тээлийн хэсгийн шимт хөрс буулгах үеийн зураг

Зураг.22



Өлзийт тээлийн хэсгийн шимт хөрс тараах үеийн зураг

Зураг.23



3.4 Биологийн нөхөн сэргээлт

2025 онд биологийн нөхөн сэргээлт ажлыг ойжуулалт болон бэлчээрийн олон наст ургамал тариалах чиглэлүүдээр хийж гүйцэтгэв. Өлийн голын хэсэгт 5.0 га талбайд бэлчээрийн олон наст ургамал тариалж, Өлзийт Тээлийн хэсэгт 1 га талбайд жимсний мод, бутыг тариалсан ба 4.0 га талбайд бэлчээрийн олон наст ургамал тариалаад байна. Биологийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэх 3 сарын хугацаанд орон нутгийн 80-100 иргэдийг цалинжуулан ажиллуулсан.

3.4.1 Ойжуулалт

Өлзийт Тээлийн хэсэгт 1 га талбайд үхрийн нүд, чацаргана, улиас, хайлаас моддыг тарьж суулгав. Хавар, намрын тариалалтанд үхрийн нүдний 2-3 настай бут болон чацаргана, хайлаас, улиас моддыг 6-р сарын 1-ээс 8-р сарын 25-нд суулгав. Дээрх моддын усалгаа, тайралт таналт, бордох ажлыг 10-р сарын 20 хүртэл хийж гүйцэтгэв. Мод суулгасан талбайг мал, амьтдаас хамгаалах зорилгоор нийт 850 м урт зориулалтын торон хашаа татсан.

Ойжуулалтын чиглэлээр нөхөн сэргээсэн ажлын хэмжээ

Хүснэгт. 6

№	Модны төрөл	Талбайн хэмжээ, га	Модны тоо, ш
1	Үхрийн нүд	1	150.0
2	Улиас		200.0
3	Хайлаас		100.0
4	Чацаргана		100
5	Нийт		550.0

Ойжуулалтанд тарьсан модод

Улиас *Хайлаас*

Зураг. 24



Үхрийн нүд



Чацаргана

Зураг. 25



Ойжуулалт хийсэн талбай

Зураг. 26



Ойжуулалт хийсэн талбай

Зураг. 27



3.4.2 Бэлчээрийн олон наст ургамал тариалсан талбай

Бэлчээрийн олон наст ургамал тариалахдаа шимт хөрсийг 20 см зузаантай дэвсэж согоовор, ботууль, царгас зэрэг олон наст ургамлуудыг тариалсан. Уг ажлыг усалгаагүй системээр 7-р сарын 1-10 хүртлэх хугацаанд хөрс сийрүүлэх болон үрлэх ажлыг хийж гүйцэтгэв. Эдгээр олон наст ургамалуудын ургац 90 хувьтай байна. Энэ нь эдгээр олон наст ургамалуудыг тухайн бүс нутагт тариалахад тохиромжтой байгааг харуулж байна. Биологийн нөхөн сэргээлтийн ажлыг MNS4918:2000 болон MNS4919:2000 стандартуудыг баримтлан ажилласан. Мөн мал амьтадаас хамгаалах зорилгоор торон хашаа татсан. Доорх хүснэгтэд биологийн нөхөн сэргээлтийн ажлын хэмжээг харуулав.

Бэлчээрийн олон наст ургамал тариалсан талбайн ажлын хэмжээ

Хүснэгт. 7

№	Үзүүлэлт	Нэгж	Утга
1	Бэлчээрийн олон наст ургамал тарьсан талбай	га	9.0
3	Хашааны хэмжээ	м	2300.0
Олон наст ургамалын үрийн зарцуулалт			
4	Царгас	кг	300.0
5	Согоовор	кг	400.0
6	Ботууль	кг	400.0
7	Ерхөг	кг	400.0
8	Нийт	кг	1500.0

Өлзийт Тээлийн хэсэгт тариалалт хийх үеийн зураг

Зураг. 28



Өлзийт тээлийн талбайн ургалтын үеийн зураг

Зураг. 29



Өлзийт тээлийн талбайн ургалтын үеийн зураг

Зураг. 30




Өлийн голын хэсэгт бэлчээрийн олон наст ургамал тариалсан талбай

Зураг. 31



Өлийн голын талбайн ургалтын үеийн зураг

Зураг. 32



Өлийн голын талбайн ургалтын үеийн зураг

Зураг. 33



Мод тариалсан талбайн солбицол

Хүснэгт. 8

№	Солбицол	
	East	North
	Өлийн голын хэсэг	
1	705910.86	5199982.40
2	705913.16	5199964.38
3	705913.33	5199960.40
4	705921.13	5199954.85
5	705930.23	5199946.03
6	705934.99	5199939.82
7	705935.86	5199937.45
8	705936.29	5199932.95
9	705925.44	5199899.22
10	705919.09	5199890.35
11	705898.59	5199862.53
12	705896.22	5199853.99
13	705893.17	5199843.04
14	705891.59	5199833.83
15	705892.00	5199821.96
16	705893.78	5199812.89
17	705897.64	5199796.84
18	705899.40	5199782.51
19	705899.40	5199782.51
20	705899.40	5199782.51
21	706149.52	5199782.51
22	706149.52	5199782.51
23	706149.52	5199782.51
24	706149.32	5199800.00
25	706147.13	5199860.43
26	706145.93	5199881.37
27	706143.60	5199922.24
28	706141.72	5199960.40
29	706140.96	5199989.43
30	706139.68	5200034.65
31	706137.44	5200114.22
32	706137.91	5200118.41
33	706018.82	5200118.51
34	705884.58	5200117.83
35	705883.90	5200092.71
36	705884.81	5200071.25
37	705898.00	5200024.46
38	705910.86	5199982.40
Өлзийт тээл-1		
1	704536.41	5200334.93
2	704528.00	5200313.43

3	704512.85	5200284.98
4	704512.85	5200284.98
5	704506.02	5200288.61
6	704476.99	5200307.52
7	704453.15	5200321.72
8	704438.58	5200329.67
9	704393.23	5200349.07
10	704383.98	5200353.48
11	704352.09	5200369.41
12	704324.69	5200381.15
13	704310.57	5200388.27
14	704278.69	5200409.07
15	704224.77	5200450.19
16	704196.41	5200462.23
17	704165.45	5200476.83
18	704147.37	5200489.26
19	704127.25	5200512.60
20	704113.96	5200531.48
21	704105.75	5200556.82
22	704106.85	5200571.54
23	704118.25	5200597.09
24	704123.37	5200608.55
25	704156.97	5200586.58
26	704196.93	5200562.69
27	704207.22	5200556.82
28	704246.39	5200530.03
29	704265.37	5200519.83
30	704306.37	5200496.23
31	704393.17	5200442.79
32	704427.45	5200423.27
33	704448.22	5200413.35
34	704455.79	5200406.94
35	704472.35	5200389.56
36	704499.11	5200361.48
37	704507.82	5200355.48
38	704517.28	5200348.96
39	704536.41	5200334.93
40	704536.41	5200334.93
41	704536.41	5200334.93
42	704536.41	5200334.93
43	704536.41	5200334.93
44	704536.41	5200334.93
45	704536.41	5200334.93

3.5 Нөхөн сэргээлтийн ажлын зардал

Нөхөн сэргээлтийн ажлын зардлын тооцоо

Хүснэгт . 16

№	Зардлын төрөл	Нэгж	Утга
Техникийн нөхөн сэргээлт			
1	Нөхөн дүүргэлт	мян.төг	4,258,800.0
3	Хэлбэржүүлэлт	мян.төг	105,800.0
4	Шимт хөрсөөр хучих	мян.төг	70,000.0
Биологи нөхөн сэргээлт			
3	**Жимсний аж ахуй**	**мян.төг**	**21,550.0**
	Модны нүх ухах	мян.төг	10,000.0
	Үхрийн нүдний суулгац	мян.төг	2,250.0
	Улиас модны суулгац	мян.төг	1,000.0
	Хайлаас модны суулгац	мян.төг	300.0
	Хашаажуулах	мян.төг	5,000.0
	Чацаргана модны суулгац	мян.төг	500.0
	Усалгаа арчилгаа	мян.төг	2,500.0
4	**Бэлчээрийн олон наст ургамал тариалалт**	**мян.төг**	**75,400.0**
	Үрийн зардал	мян.төг	60,000.0
	Царгас	мян.төг	12,000.0
	Согоовор	мян.төг	16,000.0
	Ботууль	мян.төг	16,000.0
	Ерхөг	мян.төг	16,000.0
	Хашаажуулах	мян.төг	15,000.0
	Хөрс боловсруулалт	мян.төг	400.0
5	**Ажиллах хүчний зардал**	**мян.төг**	**46,000.0**
6	**Биологийн нөхөн сэргээлтийн ажлын нийт зардал**	**мян.төг**	**142,950.0**

Нийт нөхөн сэргээлтийн ажлын зардал **4.577.55** сая.төг болж байна. Техникийн нөхөн сэргээлтийн ажлын зардлыг үйлдвэрлэлийн зардалд тооцсон.

4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

4.1 Ойн төгөл байгуулах

“Тэр бум” мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Архангай аймгийн улсын чанартай авто зам дагуу ойн зурвас байгуулах ажилд 1 га талбайд 671 ширхэг улиас модны 2 настай суулгац, нарс модны 150 ширхэг 5 настай суулгац, хайлаас модны 176 ширхэг суулгацуудыг тариалав. Мөн уурхайн бүсэд 80х80 м хэмжээтэй мод үржүүлгийн талбайг байгуулсан ба тус талбайд 6х20 м хэмжээтэй 2 ширхэг хүлэмжинд 4 төрлийн мод, бутыг үрээр болон мөчрөөр үржүүлэг хийгээд байна. Холбогдох материалыг хавсаргав.

Ойн зурвас байгуулсан ажлын талбай

Зураг. 34



Ойн зурвас байгуулсан ажлын талбай

Зураг 35



Мод үржүүлгийн хүлэмж

Зураг 36



Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын зардал

№	Гүйцэтгэх ажил	Мод/материалын үнэ	Хэмжих нэгж	Нэгж үнэ /төг/	Тоо хэмжээ	Нийт
1	Хашаа барих	Нүх ухах	ш	5,000.0	165	825,000.00
		Шон суулгах	ш	2,500.0	165	412,500.00
		Хашаа барих/тор тойруулах	м	2,500.0	500	1,250,000.00
2	Хашааны үнэ	Шон	ш	9,500.0	167	1,586,500.00
		Торон хашаа	9м	65,000.0	56	3,640,000.00
3	Мод тарих ажил	Модны нүх ухах	ш	5,000.0	997	4,985,000.00
		Хөрс бэлтгэх	м3	35,000.0	90	3,150,000.00
		Тарилт хийх	ш	8,000.0	997	7,976,000.00
		Усалгаа-арчилгаа	сар	1,200,000.0	4	4,800,000.00
4	Модны үнэ	Нарс	ш	150,000.0	150	22,500,000.00
		Хайлаас	ш	6,000.0	176	1,056,000.00
		Улиас	ш	8,000.0	671	5,368,000.00
5	Тээврийн зардал/ бусад	Тээвэр	рейс	300,000.0	2	600,000.00
		Дүн				**58,149,000.00**

4.2 Зэрлэг гахай нутагшуулах төслийн хүүрээнд хийгдсэн ажлууд:

Байгаль дээр тоо толгой нь цөөрөөд байгаа зэрлэг гахайг сэргээн нутагшуулах төслийг 2019 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Уг төслийн хүрээнд 2025 оны байдлаар нийт 35 тооны гахайг байгаль сэргээн нутагшуулсан.

Зэрлэг гахай үржүүлэг

Зураг. 37



Тус онд Цэнхэр сумын Алтан-Овоо багийн нутагт 2 мигж 6 тоорийг сэргээн нутагшуулаад байна.

Сэргээн нутагшуулах үеийн зураг

Зураг. 38



4.2 Био техникийн арга хэмжээ

Био техникийн арга хэмжээ буюу зэрлэг амьтадад өвөс тэжээл, хужир мараа тавьж өгөх ажлыг 2025 оны 12 сар болон 2026 оны 3-р саруудад зохион байгууллахаар төлөвлөж байна.

5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

Төслийн MV-001410 лицензийн талбайд орон нутгийн айлуудын зуслан, өвөлжөө хаваржаа гэх мэт бэлчээрийн болон ахуйн зориулалтаар амьдардаг газар байхгүй тул 2025 онд нүүлгэн шилжүүлэх болон нөхөн олговор олгох арга хэмжээний ажил төлөвлөгдөөгүй болно.

6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

Өлзийт тээлийн алтны шороон ордын Археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлыг 2018 онд МУИС, ШУС-ийн Антропологи, археологийн тэнхимтэй хамтран хийлгэсэн бөгөөд Хээрийн судалгаагаар эртний булш, чулуун зэвсгийн болон дундад эртний бууц суурин, хадны сүг зураг бичээс гэх мэт дурсгалын зүйлс илрээгүй. Мөн талбайн дотор ардын зан үйл явуулдаг газар, тахилгат уул овоо байхгүй байгааг судалгааны баг олж тогтоон тайлангаа “БМНС” ХХК-д хүлээлгэн өгсөн.

Мөн 2018 онд ШУА-ийн Палеонтологи, Геологийн хүрээлэнтэй хамтран Палеонтологийн хайгуул судалгааны ажил хийлгэсэн. Тайланд төслийн талбайд тархсан хурдсан палеонтологийн олдвор илрээгүй, сээр нуруутан амьтдын олдвор агуулаагүй манай улсын болон олон улсын хэмжээнд давтагдашгүй олдвортой газар биш тул цаашид уул уурхайн үйл ажиллагаа явуулах боломжтой хэмээн дүгнэв.

7. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТАЙЛАН

Хүснэгт. 17

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалахах авсан арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ
1	Цахилгааны аюулгүй байдал	Нийт ажилчдын цахилгааны аюулгүй байдлын талаархи мэдлэг, мэдээллийг сайжруулах, сургалт, зааварчилгаа тогтмол хугацаанд зохион байгуулсан	Төслийн талбайд	3 удаа
2	Гал түймэр, галын аюулгүй байдал	Нийт ажилчдын галын аюулгүй байдлын талаархи мэдлэг, мэдээллийг сайжруулах, галын хор хэрхэн зөв ашиглах талаар сургалтыг сурталчилгааг зохион байгулсан	Төслийн талбайд	3 удаа
3	Үерийн аюулаас урьдчилан сэргийлэх	Одоо ашиглагдаж байгаа үерийн далан шуудуу, хаалт зэргийг шинэчлэн сайжруулсан мөн шинээр далан шуудуу байгуулав	Төслийн талбайд	5 ш
4	Тоосжилт, зам тээврийн осол	Төслийн талбайн авто машины хөдөлгөөнд хяналт тавьж, хурдын хязгаар тогтоож тэмдэг тэмдэглэгээ байршуулан, хуурайшилт ихтэй авто замын усалгааг тогтмол хийн ажилласан	Төслийн талбайд	-
5	Болзошгүй осол, эрсдлээс сэргийлэх ХАБЭА-н сургалт зааварчилгаа	Нийт ажилчдын ХАБЭА-н хуулийг таниулах сургалт, аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгааг сар бүр өгч ажиллсан	Нийт ажилтан, албан хаагчид	6 удаа

Тэмдэг тэмдэглэгээнүүд

Зураг 39







ХАБЭА-н сургалт явуулж буй зураг

Зураг. 40



8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт. 18

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахад авсан арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ
1	Ахуйн хог хаягдал	Ажилчдын ахуйн хэрэглээнээс гарах хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах ажлыг зохион байгуулан ажиллаа	Төслийн талбайд
2	Үйл ажиллагаанаас гарах аюултай хог хаягдал	Засвар үйлчилгээ болон төлөвлөгөөт засварын ажлаас гарах шатах тослох материалын сав баглаа боодол, арчих материал зэрэг аюултай хог хаягдлыг “Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах бодлого баримтлан ажиллаа	Төслийн талбайд
3	Ахуйн хог хаягдлаа тээвэрлэх	Мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан ажилласан	Төслийн талбайд
4	Хогийн сав болон ажилчдын амьдрах байр, гал тогоонд хортон шавьжийн ариутгал халдваргүйжүүлэлт	Тусгай зөвшөөрөл бүхий “ДОБО ТРЕЙД” ХХК-аар гүйцэтгүүлэв	Уурхайн тосгон
	Нийт		

Ангилан ялгах хогийн сав

Зураг. 41





Ариутгал халдваргүйжүүлэлтийн ажил

Зураг. 42



10.ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

2025 оны орчны хяналт шинжилгээг Архангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн байгаль орчны шинжилгээний итгэмжлэгдсэн лаборатортой гэрээ байгуулан гүйцэтгүүлэв. Орчны хяналт шинжилгээний итгэмжлэгдсэн лабораторын сорилтын дүнг хавсаргав.

Хүснэгт. 19

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Давтамжийн тоо
1	Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж, Тээврийн хэрэгсэлийн яндангийн утаанд агуулагдах NO_2, SO_2 CO -ын агууламж, Хүнд металл тодорхойлох	Уурхайн ажилчдын хотхон, уурхайн дотоод зам, уурхайн каррьер	2
2	Ундны усны эрүүл ахуй, бичил биетэн ба гэдэсний бүлгийн нийт нянгийн тоо	Гал тогооны ундны усны цоргоноос	3
3	Нөхөн сэргээлт хийсэн талбайн ургамалжилт, бэлчээрийн шимт чанарын мониторинг судалгаа	2016-2024 онуудад нөхөн сэргээлт хийсэн талбай	1
4	Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөлнт фосфор, солилцих кали, карбонат, Хүнд металл(Cr, Pb, Cd, Ni, Zn), бактери	Уурхайн хог хаягдлын цэг орчим, шимт хөрсний овоолго, техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай, биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай	2
5	Төслийн талбайг дайран өнгөрч буй амьдарч буй амьтдын тохиолдолын бүртгэл мэдээлэл цуглуулах	Төслийн талбай	3
	Нийт зардал /мян.төг/		**12,804.0**

11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт. 20

Д/д	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хариуцагч	Гүйцэтгэл
1.	БОНБҮ болон БОХТ, ОХШХ-т заасан сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлэх	Ерөнхий инженер	Үйл ажиллагаандаа БОНБНҮ-д тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг БОМТөлөвлөгөөнд тусгаж тогтмол авч хэрэгжүүлэн ажилласан. Мөн ОХШХ-ийг мэргэжлийн байгууллагаар МУ-ын итгэмжлэгдсэн лабораториор дээжийг шинжлүүлэн БО-ын стандартыг мөрдөн ажиллаж байна.
2.	Байгаль орчны холбогдолтой шинээр гарсан хууль, тогтоомж, стандартыг уурхайн удирдлагуудад танилцуулах	Байгаль орчны мэргэжилтэн	Ажилчдын бүх нийтийн сургалтын хөтөлбөрт байгаль орчны сургалтын оруулж ажилчдад сургалтыг орсон.
3.	Орон нутаг болон зочид төлөөлөгчдөд байгаль орчины талаар хийгдэж байгаа ажлын талаар мэдээ мэдээллийг тогтмол өгч ажиллах	Байгаль орчны алба	Архангай аймгийн БОАЖГ болон Цэнхэр сумын ЗДТГ, орон нутгийн иргэдэд үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол мэдээллэж ажилласан.
4.	Уул уулхайн олборлолтын дараах бүс нутгийн хөгжил төслийн хүрээнд орон нутгийн жимсний аж ахуй байгуулав. Мөн малын тэжээлийн ургамал тариалж, ургацыг малчдад хүлээлгэн өгөв.	Байгаль орчны алба	Орон нутийн иргэдийг нөхөн сэргээлтийн ажилд цалинжуулан ажиллуулсан.
5.	Байгаль орчны үйл ажиллагаа, нөхөн сэргээлттэй танилцах хүсэлтэй иргэд, албан байгууллага, төлөөлөгчдөд уурхайн үйл ажиллагааг танилцуулах	Байгаль орчны мэргэжилтэн	Уурхайн үйл ажиллагаатай танилцхаар ирсэн иргэд, албан байгууллагуудад уурхайн үйл ажиллагааг нээлттэйгээр танилцуулж ажиллав.

12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ

Хүснэгт. 43

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгууласан хугацаа
1	Уурхайн үйл ажиллагаатай сум орон нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, холбогдох мэргэжилтэнүүд	Төслийн талбайд урьж уулзалт зохион байгуулсан	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний хэрэгжилт	2025 оны 9 дүгээр сар
2	Нөхөн сэргээлт хүлээлгэн өгөх. Архангай аймгийн засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг	Нөхөн сэргээлтийн талбайг танилцуулж хэмжилт хийх	Техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай	2025 оны 11-р сар
3	2025 оны БОМТ-ний хэрэгжилтийн тайлан боловсруулан Архангай аймгийн Байгаль орчны газарт хүргүүлнэ	2025 оны БОМТ-ний хэрэгжилтийн тайланг Архангай аймгийн Байгаль орчны газарт хэвлэмэл байдлаар хүргүүлсэн мөн eic.mn цахим сайтаар илгээсэн	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан	2025 оны 10 сар

Орон нутгийн иргэдэд БОМТ биелэлтийг танилцуулах хурал зохион байгуулав

Зураг. 44



2.БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АЖЛЫН НИЙТ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ

Зардлын төрөл	Нэгж	Утга
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	мян.төг	12,804.0
Нөхөн сэргээлт	мян.төг	142,950.0
Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	мян.төг	58,149.0
Хог, хаягдлын менежмент	мян.төг	3,700.0
Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	мян.төг	15,500.0
БОМТХУЗБТ-ний биелэлт	мян.төг	12,000.0
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	мян.төг	12,804.0
Нийт	**мян.төг**	**559.59**

ХАВСРАЛТ

АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ
“БМНС”ХХК-ИЙН МҮ-001410 ДУГААРТАЙ “ӨЛЗИЙТ ТЭЭЛ”
АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНЫ 5-Р САРЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАН



БОЛОВСРУУЛСАН: “ГАЗАРЧАНДМАНЬ”ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: Э.МӨНГӨНТУЯА

УЛААНБААТАР ХОТ
ГАЗАР ЧАНДМАНЬ ХХК
ЭТА0202
5203612, 8024030270

УЛААНБААТАР ХОТ
2025 ОН

Агуулга

Оршил 4
Уурхайн үйл ажиллгаа 5

Орчны хяналт шинжилгээний ажил.....6

1.1. **Агаарын чанарын хяналт, шинжилгээ..... 7**
1.2. **Ус, усан орчны хяналт шинжилгээ 10**
1.3. **Хөрсний бохирдлын хяналт, шинжилгээ 16**
2. **Ургамлын мониторинг судалгаа 22**
Дүгнэлт....., ...30

ХАВСРАЛТ

Усны хяналт шинжилгээний үр дүнгүүд
Хөрсний хяналт шинжилгээний үр дүнгүүд

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Агаарт буй тоосонцорыг хэмжсэн үзүүлэлтүүд 8
Хүснэгт 2 Уурхайн гүний худгийн ундны усны шинжилгээний үр дүн..... 10
Хүснэгт 3 Цэврийн нуур /голын/ усны шинжилгээний дүн..... 14
Хүснэгт 4 Бохир нуур /хаягдал ус/ усны хүнд металлын шинжилгээний дүн 15
Хүснэгт 5 Хүнд металлын шинжилгээний дүн 18
Хүснэгт 6 Хөрсний физик шинж чанар 19
Хүснэгт 7 Нөхөн сэргээсэн талбайн ургамлын тусгаг бүрхэц, зүйлийн бүрдэл 24

Зургийн жагсаалт

Зураг 1 Уурхайн олборлолтын байдал 5
Зураг 2 Орчны зураг 7
Зураг 3 Зам усалгаа хийгдэж буй байдал..... 8
Зураг 4 Уурхайн карьераас агаарын дээж авч буй байдал 8
Зураг 5 Ажилчдын хотхонд агаарын хэмжилт хийж буй байдал 9
Зураг 6 Уурхайн технологийн зам дээр агаарын хэмжилт хийж буй байдал 9
Зураг 7 Ундны усны дээж авч буй байдал..... 10
Зураг 8 Уурхайн технологийн ус..... 13
Зураг 9 Уурхайн технологид ашиглах голын уснаас дээж авч буй байдал 14
Зураг 10 Уурхайн ШТС..... 16
Зураг 11 ШТС талбайгаас хөрсний дээж авч буй байдал..... 17
Зураг 12 Уурхайн засварын талбай 17
Зураг 13 Уурхайн засварын талбайгаас дээж авч буй байдал..... 17
Зураг 14 Эрүүл талбайн хөрснөөс дээж авч буй байдал 21
Зураг 15 Шимт хөрсний овоолгоноос дээж авч буй байдал 21
Зураг 16 Нөхөн сэргээлт хийсэн талбайн хөрснөөс дээж авч буй байдал 22
Зураг 17 Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн төрх 24
Зураг 18 Нөхөн сэргээсэн талбайн ургамлын тусгагийн бүрхэц 25
Зураг 19 Ахуйн бохир цэвэрлэх байгууламж 27
Зураг 20 Хог хаягдлын цэг..... 27
Зураг 21 Ажилчдын угаалтуурын хэсгийн тохижилт..... 28
Зураг 22 Шимт хөрс дэвсэж буй байдал..... 28
Зураг 23 Мод тарих ажил хийж буй байдал 29

ОРШИЛ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж буй өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал,хугацааг тодорхойлохыг орчны хяналт шинжилгээний хөтөлбөр гэнэ. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон сөрөг нөлөөллийг тодорхой хугацааны давтамжтай хянах, тайлагнах, бууруулах, арилгах арга хэмжээ авахад тус хөтөлбөрийн зорилго оршино.

Тус уурхайн 2025 оны 5 сарын орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах болон төслийн үйл ажиллагаанд дараах үндсэн ач холбогдолтой. Үүнд:

- Байнгын хяналт шинжилгээ хийснээр төслөөс орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг тухай бүрд эрт илрүүлэх
- Тухайн илрүүлсэн сөрөг нөлөөллийг үндэслэн тодорхой цаг хугацааны дотор байгаль хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах

Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт орших “Өлзийт тээл”-ын MV-001410 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий алтны шороон ордод үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд жил бүр орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөсөн байна.

Орчны хяналт шинжилгээний ажлыг 2025 оны 05-р сарын 24-өөс 05-р сарын 25-ны өдрүүдэд экологич Э.Мөнгөнтуяа, байгаль орчны үнэлгээний мэргэжилтэн Ганбаатар нарын бүрэлдэхүүнтэй хийж гүйцэтгэсэн болно.

5-р сарын хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд Агаарын чанарын хяналт шинжилгээ, Гадаргын болон гүний усны хяналт-шинжилгээ, Хөрсний хяналт шинжилгээ, унд ахуйн усны чанарын хяналт зэргийг явуулахаас гадна уурхайн хүрээнд хийгдэж байгаа шинэ ажлууд болон байгаль орчны бохирдол, нөлөөлөл байгааг тогтоох,тодорхойлох мөн бохирдол нь стандартын түвшинд байгааг тогтооход оршино.

Тус хяналт шинжилгээний ажлын хүрээнд уурхайн хотхон, уурхайн карьер, техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай, шатахуун түгээх газар, засварын талбай, цэвэр болон бохирын нуур дээр очиж танилцан хөрс, усны дээж авав.

2025 оны уулын ажлын болон нөхөн сэргээлтийн төлөвлөлт

MV-001410 талбай дээр 2025 онд явагдах уулын ажил, нөхөн сэргээлтийн ажил

- ✓ **Ажиллах горим.**

Өлийн гол шороон орд 2025 оны 04-р сараас эхлэн 10-р сарыг дуустал ажиллана. Уулын ажил хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Монгол улсын хөдөлмөрийн хуульд заасны дагуу тооцон ажиллахаар төлөвлөв.

- ✓ **Үржил шимт хөрс хуулалт.**

Үржил шимт хөрсийг хуулахдаа 0.3- 0.6 м-ийн зузаантайгаар бульдозероор хуулан түрж техникийн нөхөн сэргээлт хийх үед ашиглах зорилгоор ил уурхайн олборлолтын талбайн гадна уурхайн ирмэг дагуулан түрж овоолно. Энэ нь дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийсэн (ашигласан) блокуудыг үржил шимт хөрсөөр шууд хучиж дараа дараагийн нөхөн сэргээлтийн ажлын зардлыг хэмнэх давуу талтай юм.

- ✓ **Хөрс хуулалт, тээвэрлэлтийн ажил.**

Алт агуулсан элсний тогтоц тэгш тогтвортой, гүн бага зэрэг дотоод овоолгоор төлөвлөх таатай нөхцөл байгаа тул шимт хөрсийг түрж үүсэх карьер дагуу овоолж, ашиглагдсан хоосон орон зайг хөрсөөр нөхөн дүүргэлт хийж дотоод овоолго хийж, нөхөн сэргээлтийн ажлыг хамт хийнэ. Ил уурхайн хөрсийг олборлосон орон зайг дүүргэх зорилгоор дотоод овоолгод байршуулна. Хөрс тээвэрлэлтийн ажилд HOWO маркийн 50 тн даацтай автосамосвал ажиллах ба тээвэрлэлтийн дундаж зай 0.5 км байна.



Зураг 1 Уурхайн олборлолтын байдал

- ✓ **Нөхөн сэргээлтийн ажил**

2025 оны олборлолтын үйл ажиллагаагаар эвдрэлд орсон 6 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 7га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажил хийхээр төлөвлөв. Биологийн нөхөн сэргэлтийг өөрсдийн хүн хүчээр мэргэжлийн байгууллагын зөвлөгөө авч хийх бөгөөд нөхөн сэргээлтийн стандартын дагуу нөмөрлөгч болон олон наст малын идэмж сайн ургамлын үрийг тариална.

ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ

Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт “БМНС”ХХК-ний MV-001410 тусгай зөвшөөрлийн талбайд алтны шороон ордод олборлолт явуулж байгаа бөгөөд жил бүр орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Орчны хяналт шинжилгээний ажлыг 2025 оны 5-р сарын 24-аас 5-р сарын 25-ны өдрүүдэд экологич Э.Мөнгөнтуяа, байгаль орчны үнэлгээний мэргэжилтэн хийж гүйцэтгэсэн.



Зураг 2 Уурхайн ажилчдын кемп



Зураг 3 Уурхайн ажилчдын кемп

АГААРЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ

Тус ажлын хүрээнд бид уурхайн карьер, тээвэрлэлтийн зам, хотхоны орчим зэрэг газар агаарт буй ширхэглэгт тоосонцрыг, дуу чимээ, агаарын харьцангуй чийгшил, салхины хурд, агаарын температур, гэрлийн хүч зэргийг хэмжиж суурин боловсруулалтын хүрээнд тус хэмжиж авсан хэмжилтийг “Агаарын техникийн ерөнхий шаардлага ” MNS 4585:2025 стандарттай харьцуулсан.

Агаарын тоосжилтын үр дүн:

Монгол Улсын “Агаарын техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2025 стандарт тоосны агууламж PM 10, Хүхэрлэг хий, Азотын давхар исэл зэрэг үзүүлэлт нь 24 цагийн дундаж үзүүлэлтээр үзсэн. Бидний хэмжилт хийсэн газруудад агаарын техникийн ерөнхий шаардлага стандартаас давсан үзүүлэлт байхгүй байна.



Зураг 4 Зам усалгаа хийгдэж буй байдал

Хүснэгт 1 Агаарт буй тоосонцрыг хэмжсэн үзүүлэлтүүд


№	Байршил	Сар өдөр	Хүхэрлэгхий /SO_2/ мг/м^3	Азотынхий /NO_2/ мг/м^3	Тоосны агууламж PM 10 мкг/м^3	Дуу чимээ дбА	Чийг-шил
1.	Хотхон	05/25	0.021	0.033	10	40	max 40.4% min 18.4%
2.	Технологийн зам	05/25	0.015	0.045	6	30	
3.	Уурхайн карьер	05/25	0.022	0.035	4	35	
	MNS 4585:2025 стандарт	**-**	**0.450**	**0.200**	**100**	60.0 дбА	40-60%



Зураг 5 Уурхайн карьераас агаарын дээж авч буй байдал



Зураг 6 Ажилчдын хотхонд агаарын хэмжилт хийж буй байдал



Зураг 7 Уурхайн технологийн зам дээр агаарын хэмжилт хийж буй байдал

Уурхайн тоосжилттой тэмцэх арга хэмжээ:

Уурхайн олборлолтын бүс, уурхайн дотоод тээвэрлэлтийн явцад тоосжилт, тоос их хэмжээгээр үүсдэг. Тус уурхайн хувьд тоосжилтын дарах услах зориулалтын арга хэмжээнд ашигладаг усалгааны машинтай. Зам талбай тоосжилтыг тогтмол дарах, чийглэх арга хэмжээ авахаас гадна дараах арга хэмжээг авч шаардлагатай. Үүнд:

- ✓ Тоног төхөөрөмж ажиллаж буй талбай, мөргөцгийг услах
- ✓ Ээлж бүр тоног төхөөрөмжийн кабинд чийгтэй цэвэрлэгээ хийх
- ✓ Авто зам ба овоолгыг усалж байх

УУРХАЙН УСНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ

Уурхайн унд ахуйн усны шинжилгээ, хяналт

Уурхай нь улирлын чанартай ажиллах ба уурхайн хотхонд ажилчид ажиллаж амьдарна. Унд ахуйн усны хэрэгцээг гүний худгын усаар хангана. Хяналт шинжилгээний ажлын хүрээнд тус уурхайн унд ахуйн усанд бактериологийн шинжилгээ болон унд ахуйн усны ерөнхий шинжилгээг тус тус хийлгэж стандарт үзүүлэлттэй харьцуулсан болно.



Зураг 8 Ундны усны дээж авч буй байдал

Хүснэгт 2 Уурхайн гүний худгийн ундны усны шинжилгээний үр дүн

№	Үзүүлэлт	Шинжлэх аргын стандарт	Ундны ус.Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 900: 2018 ЗДХ	2025.05
1	pH-Усны орчин	MNS ISO 10523-2001	6.5-8.5	7.23
2	Цахилгаан дамжуулах чанар, µS/cm	MNS ISO 7888:1999	1.0	0.382
3	Ерөнхий хатуулаг, мг-экв/л	MNS ISO 6059:2005	7.0	3.61
4	Кальци, (Ca2+) мг/л	MNS 1097:1970	100.0	56.00
5	Магни, (Mg2+) мг/л	Тооцооны арга	<30.0	10.00
6	Карбонат, (CO3-) мг/л	MNS ISO 9963-1:2005	-	0.00

7	Хлорид, (Cl-) мг/л	MNS ISO 9297:2005	<350.0	14.00
8	Гидрокарбонат, (HCO3-) мг/л	MNS ISO 9963-1:2005	-	220.00
10	Төмөр, (Fe3+) мг/л	MNS 4430:2005	0.3	0.00
